



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын Ерөнхий боловсролын III сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2026/25/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Сайнжаргал Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com Аудитор: Б.Болормаа Утас: 88099949 Цахим хаяг: info.iedca@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Ерөнхий боловсролын III сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Шалгагдагч байгууллага нь тендер шалгаруулалтыг явуулахдаа оролцогчоос санал болгосон бараа, ажил, үйлчилгээ нь тендерийн баримт бичигт тусгагдсан техникийн тодорхойлолт, шаардлагад бүрэн нийцсэн эсэхийг нягтлан шалгаагүй, үнэлгээ хийх явцад холбогдох баримт бичиг, нотолгоог бүрэн бүрдүүлээгүй, мөн батлагдсан төсөвт тусгагдсан худалдан авах ажиллагаа зохион байгуулах шаардлагатай зардлыг жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, төсвийг хувааж шууд худалдан авалт хийж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байна.

## Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн ажил гүйлгээтэй холбоотой 12.7 сая төгрөгийн алдаа илрүүлж, залруулсан.

## Бусад асуудал

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой

нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>559,685,639.94</b>	<b>582,650,657.12</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	252,921,549.55	241,166,927.61
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	252,921,549.55	241,166,927.61
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	252,921,549.55	241,166,927.61
31211	Төрийн сангийн харилцах	252,921,549.55	241,166,927.61
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	23,601,985.72
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	607,211.72
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	22,994,774.00
3351	Байгууллагаас авах авлага	-	22,994,774.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	306,764,090.39	317,881,743.79
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	192,626,982.91	194,332,707.31
35110	Тусгай зориулалттай материал	192,501,789.91	194,309,983.11
35130	Эм боох материал	125,193.00	22,724.20
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	114,137,107.48	123,549,036.48
35410	Бичиг хэргийн материал	466,800.00	427,300.00
35420	Аж ахуйн материал	111,287,567.48	122,539,356.48
35440	Түлш, шатах тослох материал	660,000.00	550,000.00
35460	Хүнсний материал	1,722,740.00	32,380.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,020,857,618.56</b>	<b>3,961,456,295.59</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,020,857,618.56	3,961,456,295.59
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,668,217,618.24	3,607,197,233.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,016,869,079.49	4,016,869,079.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(801,592,975.45)	(902,159,474.89)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	465,589,441.80	500,820,836.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(175,784,621.88)	(235,584,437.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	261,843,000.16	274,258,450.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(187,120,172.93)	(128,541,821.18)
39209	Зам, гүүрийн байгууламж	75,367,087.00	75,367,087.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(46,316,497.81)	(55,693,344.91)
39214	Бусад үндсэн хөрөнгө	39,224,216.60	47,717,490.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,978,791.54)	(19,469,485.05)
39217	Ном	33,117,852.80	33,612,852.80
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	352,640,000.32	354,259,062.52
39301	Програм хангамж	1,727,000.00	1,727,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,726,999.68)	(107,937.48)
39303	Бусад биет бус хөрөнгө	352,640,000.00	352,640,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,580,543,258.50</b>	<b>4,544,106,952.71</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>16,613,800.00</b>	<b>2,868,362.02</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	16,613,800.00	2,868,362.02
<b>413</b>	<b>Өглөг</b>	16,613,800.00	2,868,362.02
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	817,162.02
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	2,051,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,051,200.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,563,929,458.50</b>	<b>4,541,238,590.69</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,563,929,458.50	4,541,238,590.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,272,989,524.54	1,272,989,524.54
51101	Өмч: - төрийн	1,272,989,524.54	1,272,989,524.54
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	3,112,342,946.19	3,089,652,078.38
51210	Өмнөх үеийн үр дүн	3,112,342,946.19	3,112,342,946.19
51220	Тайлант үеийн үр дүн	-	(22,690,867.81)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	178,596,987.77	178,596,987.77
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,580,543,258.50</b>	<b>4,544,106,952.71</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,389,627,299.40</b>	<b>3,935,235,786.04</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>281,588,959.20</b>	<b>321,826,388.25</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	281,588,959.20	321,826,388.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,030,848.00	9,276,384.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,030,848.00	9,276,384.00
120009	Бусад орлого	-	50,584,700.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	239,136,840.40	196,655,606.05
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал	26,421,270.80	65,309,698.20
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,108,038,340.20</b>	<b>3,613,409,397.79</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,771,397,300.00</b>	<b>3,262,222,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,771,397,300.00	3,262,222,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>336,641,040.20</b>	<b>351,187,297.79</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	336,641,040.20	351,187,297.79
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,235,440,392.90</b>	<b>3,957,926,653.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,235,440,392.90</b>	<b>3,957,926,653.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,104,821,892.90</b>	<b>3,800,408,557.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,077,536,373.90</b>	<b>2,558,913,703.66</b>
210101	Үндсэн цалин	1,309,272,185.84	1,644,000,264.35
210102	Нэмэгдэл	688,214,560.62	786,631,417.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,471,295.20	88,758,141.34
210104	Урамшуулал	31,578,332.24	39,523,880.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>258,318,995.94</b>	<b>307,693,612.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	175,694,917.49	210,256,708.56
210202	Тэтгэмжийн даатгал	20,677,808.61	25,343,043.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,338,754.30	12,648,322.11
210204	Ажилгүйдлийн даатгал	10,299,337.30	11,810,358.96
210205	Эрүүл мэндийн даатгал	41,308,178.24	47,635,179.67
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>328,641,070.20</b>	<b>331,193,337.79</b>
210301	Гэрэл, цахилгаан	25,326,463.20	28,037,936.76
210302	Түлш, халаалт	230,269,749.00	274,074,258.00
210303	Цэвэр, бохир ус	73,044,858.00	29,081,143.03
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>49,753,620.26</b>	<b>57,016,302.00</b>
210401	Бичиг хэрэг	1,919,783.00	2,738,600.00
210402	Тээвэр, шатахуун	40,000.00	110,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,372,867.50	37,820,494.00
210408	Бараа материал акталсны зардал	20,420,969.76	16,347,208.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>51,066,560.00</b>	<b>124,394,978.80</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	288,129.00	102,468.80
210502	Хоол, хүнс	50,778,431.00	124,292,510.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,277,820.00</b>	<b>12,798,320.00</b>
210604	Урсгал засвар	6,277,820.00	12,798,320.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>53,406,750.00</b>	<b>49,033,277.48</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,807,571.00	6,920,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,051,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	38,599,179.00	40,061,377.48
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>279,820,702.60</b>	<b>359,365,025.13</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,449,523.00	52,215,146.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,912,200.00	17,390,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	224,458,979.60	289,759,379.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>130,618,500.00</b>	<b>157,518,096.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>130,618,500.00</b>	<b>157,518,096.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	115,522,500.00	145,104,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,096,000.00	12,413,996.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>154,186,906.50</b>	<b>(22,690,867.81)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>153,883,606.50</b>	<b>(22,690,867.81)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>3,142,069,188.20</u></b>	<b><u>3,673,270,481.79</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>34,030,848.00</b>	<b>59,861,084.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	34,030,848.00	59,861,084.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,030,848.00	9,276,384.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,030,848.00	9,276,384.00
120009	Бусад орлого	18,000,000.00	50,584,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,108,038,340.20</b>	<b>3,613,409,397.79</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,771,397,300.00</b>	<b>3,262,222,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,771,397,300.00	3,262,222,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>336,641,040.20</b>	<b>351,187,297.79</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	336,641,040.20	351,187,297.79
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>3,043,170,154.10</u></b>	<b><u>3,651,322,653.73</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,043,170,154.10</b>	<b>3,651,322,653.73</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,927,835,154.10</b>	<b>3,455,606,233.73</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,095,536,373.90</b>	<b>2,558,703,753.36</b>
210101	Үндсэн цалин	1,327,272,185.84	1,643,790,314.05
210102	Нэмэгдэл	688,214,560.62	786,631,417.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,471,295.20	88,758,141.34
210104	Урамшуулал	31,578,332.24	39,523,880.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>258,212,117.00</b>	<b>307,693,612.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	175,694,917.49	210,256,708.56
210202	Тэтгэмжийн даатгал	20,677,808.61	25,343,043.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,338,754.30	12,648,322.11
210204	Ажилгүйдлийн даатгал	10,299,337.30	11,810,358.96
210205	Эрүүл мэндийн даатгал	41,201,299.30	47,635,179.67
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>328,641,070.20</b>	<b>331,193,337.79</b>
210301	Гэрэл, цахилгаан	25,326,463.20	28,037,936.76
210302	Түлш, халаалт	272,288,963.00	274,074,258.00
210303	Цэвэр, бохир ус	31,025,644.00	29,081,143.03
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>50,858,150.00</b>	<b>56,178,400.00</b>
210502	Хоол, хүнс	50,858,150.00	56,178,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,999,970.00</b>	<b>19,993,960.00</b>
210604	Урсгал засвар	7,999,970.00	19,993,960.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>66,066,886.00</b>	<b>55,202,077.48</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,682,657.00	6,920,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	50,384,229.00	48,281,377.48
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>120,520,587.00</b>	<b>126,641,092.11</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	97,608,387.00	109,250,592.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,912,200.00	17,390,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>115,335,000.00</b>	<b>195,716,420.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>115,335,000.00</b>	<b>172,721,646.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	100,239,000.00	160,175,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,096,000.00	12,545,996.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>22,994,774.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	22,994,774.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>98,899,034.10</u></b>	<b><u>21,947,828.06</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>43,197,800.00</b>	<b>33,702,450.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>43,197,800.00</b>	<b>33,702,450.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>43,197,800.00</b>	<b>33,702,450.00</b>
223001	Бусад хөрөнгө	400,000.00	33,702,450.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(43,197,800.00)</u></b>	<b><u>(33,702,450.00)</u></b>

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	55,701,234.10	(11,754,621.94)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		252,921,549.55
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	252,921,549.55	241,166,927.61

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,272,989,524.54	178,596,987.77	3,112,342,946.19	4,563,929,458.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,272,989,524.54	178,596,987.77	3,112,342,946.19	4,563,929,458.50
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(22,690,867.81)	(22,690,867.81)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,272,989,524.54	178,596,987.77	3,089,652,078.38	4,541,238,590.69

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,090,423,800.00	3,662,030,329.73	428,393,470.3	89.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,090,423,800.00	3,662,030,329.73	428,393,470.3	89.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,894,092,500.00	3,489,308,683.73	404,783,816.3	89.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,746,011,800.00	2,558,703,753.36	187,308,046.6	93.2
210101	Үндсэн цалин	1,798,729,300.00	1,643,790,314.05	154,938,986.0	91.4
210102	Нэмэгдэл	931,667,100.00	786,631,417.97	145,035,682.0	84.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	88,758,141.34	(88,758,141.3)	0.0
210104	Урамшуулал	15,615,400.00	39,523,880.00	(23,908,480.0)	253.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	343,281,700.00	307,693,612.99	35,588,087.0	89.6
210201	Тэтгэврийн даатгал	233,431,600.00	210,256,708.56	23,174,891.4	90.1
210202	даатгал Тэтгэмжийн	27,462,600.00	25,343,043.69	2,119,556.3	92.3
210203	даатгал ҮОМШӨ-ний	13,731,200.00	12,648,322.11	1,082,877.9	92.1
210204	даатгал Ажилгүйдлийн	13,731,200.00	11,810,358.96	1,920,841.0	86.0
210205	даатгал Эрүүл мэндийн	54,925,100.00	47,635,179.67	7,289,920.3	86.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	365,272,200.00	331,193,337.79	34,078,862.2	90.7
210301	Гэрэл, цахилгаан	32,119,800.00	28,037,936.76	4,081,863.2	87.3
210302	Түлш, халаалт	300,069,000.00	274,074,258.00	25,994,742.0	91.3
210303	Цэвэр, бохир ус	33,083,400.00	29,081,143.03	4,002,257.0	87.9
2105	Нормативт зардал	64,154,100.00	56,178,400.00	7,975,700.0	87.6
210502	Хоол, хүнс	64,154,100.00	56,178,400.00	7,975,700.0	87.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	19,993,960.00	6,040.0	100.0
210604	Урсгал засвар	20,000,000.00	19,993,960.00	6,040.0	100.0

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	56,403,700.00	55,202,077.48	1,201,622.5	97.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,991,400.00	6,920,700.00	70,700.0	99.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	49,412,300.00	48,281,377.48	1,130,922.5	97.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	298,969,000.00	160,343,542.11	138,625,457.9	53.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	281,315,100.00	142,953,042.11	138,362,057.9	50.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,653,900.00	17,390,500.00	263,400.0	98.5
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	196,331,300.00	172,721,646.00	23,609,654.0	88.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	196,331,300.00	172,721,646.00	23,609,654.0	88.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	183,767,300.00	160,175,650.00	23,591,650.0	87.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,564,000.00	12,545,996.00	18,004.0	99.9
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	4,090,423,800.00	3,673,270,481.79	417,153,318.2	89.8
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,283,114,100.00	3,262,222,100.00	20,892,000.0	99.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,283,114,100.00	3,262,222,100.00	20,892,000.0	99.4
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	385,272,200.00	351,187,297.79	34,084,902.2	91.2
132001	Орон нутгийн төсвөөс	385,272,200.00	351,187,297.79	34,084,902.2	91.2
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	422,037,500.00	59,861,084.00	362,176,416.0	14.2
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,254,800.00	20,115,724.00	(860,924.0)	104.5
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	169,653,100.00	39,745,360.00	129,907,740.0	23.4
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>252,921,549.55</b>	(252,921,549.6)	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>241,166,927.61</b>	(241,166,927.6)	

---

### 3. Аудитын илрүүлэлт

---

Аудитаар нийт 12.7 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 12.7 сая төгрөгийн 3 алдааг залруулан, 2 зөвлөмж хүргүүлсэн.

#### Аудитын явцад залруулсан алдаа:

1. 2024 оны ХХОАТ-ын өглөгийн дансны эцсийн үлдэгдэл 11.3 сая төгрөгийг тайлант оны цалингийн зардал дансанд тусгасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “Ерөнхий нягтлан бодогч нь холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах үүрэг хүлээнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2. Тайлант оны НДШ-ийн зардлыг 0.6 сая төгрөгөөр илүү дүнгээр тусгаж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3. Цалингаас суутгасан ҮЭ-ийн 0.8 сая төгрөгийн суутгалыг буруу бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### 3.1. Төлбөрийн акт:

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 3.2. Албан шаардлага:

Аудитаар албан шаардлага хүргүүлээгүй болно.

#### 3.3 Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Хууль журмын хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт 1:**Тендер шалгаруулалтын явцад оролцогчоос санал болгосон бараа, ажил, үйлчилгээ нь тендерийн баримт бичигт тусгагдсан техникийн тодорхойлолт, шаардлагад бүрэн нийцсэн эсэхийг хангалттай нягтлан шалгаагүй, үнэлгээ хийх явцад холбогдох баримт бичиг, нотолгоог бүрэн бүрдүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.2 “Санал болгосон бараа,

---

---

*ажил, үйлчилгээ нь тендерийн баримт бичигт заасан техникийн тодорхойлолт, шаардлагад нийцсэн байх”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.*

**Өгсөн зөвлөмж:** Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу ил тод, шударга, үр ашигтай зохион байгуулах.

**Илрүүлэлт 2:** Батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулах тендер шалгаруулалтын ажлыг жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, үнийн дүнг хуваан, шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Худалдан авах ажиллагааг жилийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулна”, 6.3 “Худалдан авах ажиллагааг тендерийн аргаас зайлсхийх зорилгоор бараа, ажил, үйлчилгээг хэсэгчлэн хувааж худалдан авахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад **2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор** ирүүлнэ үү.

---

#### 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруул аагүй	Тоо	Дүн		
2024 оны ХХОАТ-ын өглөгийн дансны эцсийн үлдэгдэл 11.3 сая төгрөгийг тайлант оны цалингийн зардал дансанд тусгасан	1	11,345.3			1	11,345.3	1	11,345.3				
Тайлант оны НДШ-ийн зардлыг 0.6 сая төгрөгөөр илүү дүнгээр тусгаж тайлагнасан	1	607.2			1	607.2	1	607.2				
Цалингаас суутгасан ҮЭ-ийн 0.8 сая төгрөгийн суутгалыг буруу бүртгэсэн.	1	817.2			1	817.2	1	817.2				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>12,769.7</b>			<b>3</b>	<b>12,769.7</b>	<b>3</b>	<b>12,769.7</b>	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/			
							Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тендерийн баримт бичигт үнэлгээ бүрэн хийгээгүй	1	0					1	0		
Төсөвт өртгийг хувааж ХАА зарласан.	1	0					1	0		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>0</b>					<b>2</b>	<b>0</b>		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.